



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар A/723

Арвайхээр

### Г Тооллого зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “г”, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Засгийн газрын 2003 оны “Тооллогын товыг тогтоох тухай” 224 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллогыг 2019 оны 12 дугаар сарын 07-ноос 17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн 2019 оны тооллогыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
3. Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллогын бэлтгэл ажлыг хангах, тооллого явуулах ажлын хэсгийг сумдад байгуулж, ажилтнуудыг сургах, хяналтын тооллого хийх, тооллогын дүнг нэгтгэх үйл ажиллагааны зардалд 2000000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.
4. Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллого явуулахтай холбогдон гарах шууд зардлыг санхүүжүүлэхийг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.
5. Тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймаг, сумын түвшинд хангаж, тооллогыг тогтоосон хугацаанд нь заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101383

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2019 оны 12  
дугаар сарын 04-ны өдрийн 12 дугаар  
захирамжийн хавсралт

## МАЛ ТООЛЛОГЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн - Аймгийн Засаг даргын орлогч  
Гишүүд: О.Түмэнжаргал –Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн  
хэлтсийн дарга

С.Цэдэнбалжир – Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын дарга

Б.Цэнгэл -Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын Мал аж ахуйн албаны дарга

А.Нямдаваа -Аймгийн мал эмнэлэгийн албаны дарга

С.Зоригтбаатар - Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,  
барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга –Х.Мөнхцэцэг -Аймгийн Засаг даргын дэргэдэх  
Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

-оOo-